



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/276

Есөнбулаг

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 63 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдад төрийн үйлчилгээг хүргэх, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд иргэдийг халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгооны хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахад багт ажилласан багийн эмч, эмч нартай гэрээ байгуулан, гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

2. Тус арга хэмжээнд шаардагдах 88,000,000 (наян найман сая) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/276 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2014 оны
05 дугаар сарын 09-ны өдрийн /14/ дүгээр
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

| № | Зардлын нэр | Нийт үнэ | Хөрөнгийн эх үүсвэр |
|--|---------------|------------|---------------------------------------|
| Багт ажилласан их эмч, багийн эмч нарт олгох дэмжлэг | | | |
| № | Сумын нэр | Багийн тоо | Говь-Алтай 80+ эрүүл мэндийн хөтөлбөр |
| 1 | Алтай сум | 4 | 4.000.000 |
| 2 | Баян-Уул сум | 6 | 6.000.000 |
| 3 | Бигэр сум | 5 | 5.000.000 |
| 4 | Бугат сум | 5 | 5.000.000 |
| 5 | Дарив сум | 4 | 4.000.000 |
| 6 | Дэлгэр сум | 5 | 5.000.000 |
| 7 | Жаргалан сум | 3 | 3.000.000 |
| 8 | Тайшир сум | 3 | 3.000.000 |
| 9 | Тонхил сум | 5 | 5.000.000 |
| 10 | Төгрөг сум | 5 | 5.000.000 |
| 11 | Халиун сум | 4 | 4.000.000 |
| 12 | Хөхморьт сум | 5 | 5.000.000 |
| 13 | Цогт сум | 7 | 7.000.000 |
| 14 | Цээл сум | 4 | 4.000.000 |
| 15 | Чандмань сум | 5 | 5.000.000 |
| 16 | Шарга сум | 4 | 4.000.000 |
| 17 | Эрдэнэ сум | 4 | 4.000.000 |
| 18 | Есөнбулаг сум | 10 | 10.000.000 |
| | Нийт дүн | 88 | 88.000.000 |